

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

**СЭТГҮҮЛ ЗҮЙН АРГА ЗҮЙ БА АРГЫГ БОЛОВСРУУЛАХ ОНОЛ,
ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛД**

М.Зулькафиль*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн, Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: сэтгүүл зүйн арга зүй, логик үйлдэл, мэдлэгийн систем, шинэ технологи, шинжлэх ухааны түвшин, хөгжлийн зүй тогтлууд, оюун дүгнэлт.

Сүүлийн жилүүдэд бодит байдлыг таньж мэдэх сэтгүүл зүйн арга ба арга зүйн асуудал судлаачдын анхаарлыг ихээхэн татах болсон. Энэ нь нэг талаар сэтгүүл зүй нийгэм-хүмүүнлэгийн маш олон салбар шинжлэх ухааны зааг дээр оршдогтой, нөгөө талаар шинжлэх ухаан болон төлөвших үйл явц нь харьцангуй богино хугацааг хамардагтай холбоотой юм. Тиймээс энэ талаар судлаачид ямар санал зөвлөмж, таамаглал дэвшүүлж, ямар дүгнэлт хийж байгаатай танилцах нь зарчмын чухал ач холбогдолтой юм.

Эхлээд арга зүйн талаар ерөнхий ойлголт өгөхийг оролдоё. Арга зүй гэдэг бол аливаа шинжлэх ухаанд хэрэглэж буй арга, хэрэгсэл, технологийг хамарсан мэдлэгийн салбар юм. Өөрөөр хэлбэл арга зүй гэдэг нь шинжлэх ухааны дэвшүүлэн тавьж байгаа зорилтуудыг зөв, бүрэн төгс шийдвэрлэх боломжоор хангахад чиглэгдсэн аргуудыг хэрэглэх үйлдлүүд, систем, мөн чанарын тухай сургаал

гэсэн үг. Түүнчлэн арга зүй бол сэтгүүл зүйн үзэгдлүүдийг судлахад хэрэглэх логик үйлдлүүд, тусгай аргуудын систем юм. Гэхдээ арга зүй гэдэг нь зөвхөн судалгааны тодорхой аргууд, үйлдлүүдийн нийлбэр төдий зүйл биш бөгөөд тодорхой объектийг судлахад баримтлах онцгой хандлагууд ба зарчмуудын нэгдмэл системийг боловсруулах явдал мөн. Өөрөөр хэлбэл зөвхөн бий болсон мэдлэгийн нийлбэрээр бус, үзэгдлийг таньж мэдэх сэтгүүл зүйн ажиллагааны үйл явцын онцлогоор тодорхойлогдох систем юм.

Уламжлал ёсоор арга зүйг дөрвөн томоохон салбарт ангилдаг. Үүнд:

- a) Танин мэдэхүйн ерөнхий арга зүй
- b) Шинжлэх ухааны танин мэдэхүйн аргууд
- c) Шинжлэх ухааны болон танин мэдэхүйн бүтээлч үйл ажиллагааны арга зүйн үндсүүд
- d) Тайлбарлан өгүүлэх арга зүйн зарчмууд зэрэг юм.

Танин мэдэхүйн ерөнхий арга зүй бол бүх шинжлэх ухааны ертөнцийг үзэх үзэл, ерөнхий арга зүйн чиг баримжаа, үндсэн утга санааг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Сэтгүүл зүй бусад бүх шинжлэх ухааны нэгэн адил нийгэм-түүхийн танин

мэдэхүйн ерөнхий хуулиудад захирагддаг. Сэтгүүлчийн болон редакцийн хамт олны бүтээлч үйл ажиллагаа нь нийгмийн практикийн хуулиудын үндсэн дээр хэрэгждэг. Бодит байдлыг ойлгох зарчмын чиг баримжаа бол сэтгүүлчид философи, эдийн засаг, ёс зүй, гоо зүй, логик, нийгмийн удирдлагын болон уран сайхны танин мэдэхүйн онолын салбарын мэдлэг олж авахад тусалдаг. Сэтгүүлчид бодит байдлыг үнэн зөв ойлгох, ул суурьтай үнэлж цэгнэхийн тулд нийгмийн хөгжлийн ерөнхий хуулиудыг заавал мэдэх шаардлага тулгардаг. Суурь мэдлэг бол судлаачийн хувьд зөвхөн их эрдмийн үндэс төдий зүйл биш, харин түүнгүйгээр нийгмийн практикийг судлах боломжгүй бааз юм¹.

Шинжлэх ухааны танин мэдэхүйн аргуудыг судлах аргууд болон *тайлбарлан өгүүлэх* аргууд гэж хоёр хуваадаг. Судлах аргуудад үзэгдэл, бодит байдлын объектуудыг танин мэдэх арга, үйлдлүүдийн систем багтдаг. Тэд судлаачид үзэгдлийн мөн чанар, онцлог шинжүүдийг таньж мэдэх, түүний ажиллагаа, хөгжлийн зүй тогтлууд болон бусад үзэгдлүүдийн хоорондын харилцаа холбоог илрүүлэхэд тусалдаг.

Тайлбарлан өгүүлэх аргуудад үзэгдэл, объектийг судлах явцад олж авсан баримт, мэдээллүүдийг хүлээн авагчдад танилцуулах, тайлбарлах арга, үйлдлүүдийн систем багтдаг. Тэд бүхэлдээ ямар нэгэн үзэгдлийн сайн талын талаарх төсөөлөлд үндэслэгдсэнээрээ онцлогтой юм.

Шинжлэх ухааны танин мэдэхүйн ерөнхий аргуудыг онолын болон туршилтын түвшинд хэрэглэдэг. Онолын судалгаа нь бодит байдлыг түүний зүй тогтлууд, харилцан уялдаа холбоонд нь бүх талаас нь таньж

мэдэхэд чиглэгддэг. Тийм судалгаа бол логик сэтгэлгээ, хийсвэрлэн тунгаан бодохуйд үндэслэгдсэн сэтгэхүйн арга, үйлдлүүдийг шаарддаг. Ингэхдээ сэтгэхүй нь *эргэцүүлэл, өгүүлэмж, оюун дүгнэлт, индукци (ерөнхийгөөс нэгж руу), дедукци (нэгжээс ерөнхий руу), задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, аналогу (адилтгал)* гэх мэт хэлбэрээр илэрдэг нь түгээмэл юм. Энд бодит ертөнц бол тусгай үзэгдлүүдийн энгийн нэг нэгдэл биш, маш олон зүйлийг тэдний мөн чанарын хамт агуулсан бүхэл бүтэн систем гэдгийг ойлгох хэрэгтэй. Гэхдээ тэр мөн чанарыг хүн шууд мэдрэх, ажиглах, мэдрэхүйгээр ил тод илэрхийлэх боломжгүй. Тийм учраас мөн чанарыг таньж мэдэх цорын ганц арга бол онолын бүдүүвчийг зохиоход оршино. Энэ зорилгоор шинжлэх ухааны танин мэдэх ажиллагаанд арга зүйн янз бүрийн хандлагуудыг хэрэглэдэг онцлогтой. Ийм хандлагын зарим нэгийг товч авч үзье.

Феноменологийн хандлага нь хүний ухамсар болон философийн соёлын уг чанарыг илэрхийлдэг оюун санааны мөн чанарт дүн шинжилгээ хийхэд чиглэгдсэн байдаг. Сэтгүүлч өөрийнхөө өгүүлэл, найруулал, эссе зэрэг нийтлэлд тодорхой соёлыг агуулагч-хүний мөн чанарт нэвтэрч, ухамсрын төлөвшлийн үйл явцыг харуулж, түүний оюун санааны үндсийг нээж өгөх боломжтой. Сэтгүүл зүй шинжлэх ухаан, технологи, урлаг, нийгмийн харилцаа зэрэг нийгмийн олон асуудлыг хөндөхийн зэрэгцээ соёл иргэншлийн болон соёлын хөгжлийн чиг хандлагыг харуулж чаддагаараа онцлогтой.

Харьцуулан судлах хандлага бол философийн соёлын мөн чанар, гарал үүслийг тодорхойлдог. Харьцуулалт бол объектийн мөн чанарыг таньж

мэдэх энгийн, үр ашигтай арга бөгөөд түүний үр дүнд хоёр ба түүнээс дээш тооны объектэд байдаг нийтлэг шинжүүдийг тогтоодог. Энэ арга бол баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ голлон хэрэглэдэг туршилтын аргад багтдаг. Объектийг харьцуулан судлах аргын үндэс нь судалж буй үзэгдлүүдийн ижил төстэй болон ялгаатай шинжүүдийг тогтооход чиглэгдсэн задлан шинжилгээ байдаг. Гэхдээ тийм формаль логикийн дүн шинжилгээ бол онолын мэдлэгийн зөвхөн урьдач нөхцөл төдий зүйл гэдгийг анхаарвал зохино.

Компаратив буюу түүхэн харьцуулан судлах арга зүй бол дэлхийн болон үндэстний философи уламжлалыг нийгэм-соёлын үүднээс харьцуулан судлах шалгууруудыг тогтоох боломж олгохын зэрэгцээ тэднийг нэгдмэл зүйлийн салшгүй нэг хэсэг мөн гэдгийг нотлоход тусалдаг. Энэ арга философийн түүхэн дэх нэгдэн нийлэх болон ижилсэх үйл явцуудын харилцан нөлөөлөх механизмуудыг тайлбарлах, философийн уламжлалыг тунгаан бодоход чухал үүрэгтэй. Гэхдээ энэ арга универсаль шинжтэй биш юм.

Түүхэн философийн шинжилгээний арга зүй харьцуулах объектуудыг хамрах хүрээ (микро- ба макрохарьцуулалт) болон агуулгын багтаамж гэсэн хоёр үндсэн шинжээр ангилах боломж олгодог. Микрохарьцуулалтын түвшинд харьцуулалтын судлагдахуун нь нэг асуудлын талаарх нэг эсвэл хэд хэдэн сэтгэн бодогчийн бүтээл байж болно. Макрохарьцуулалтын түвшинд философийн дэг сургууль ба чиглэлүүдийг, гүн ухаанчлах үндэсний хэлбэрүүд, философи сэтгэлгээний түүхэн хэв маягууд, философи болон нийгмийн

ухамсрын бусад хэлбэрүүдийг харьцуулан судалдаг².

Үг зүйн хандлага бол философийн соёлын агуулгыг бүтцийн үүднээс харах боломж олгодог, харин философи-хүн судлалын хандлага бол философийн соёлыг зөөгчдийг тодорхойлох онцлогтой юм. Эрдэмтдийн тухай найруулал, хөргүүд янз бүрийн сэтгэгчдийн үзэл санааг сэргээн санах боломж олгодог давуу талтай (Гегель-Груссель; Фрейд-Маркс; Паскаль-Нище г.м.).

Ертөнцийг үзэх хандлага бол соёлыг бүтээгчид, агуу их бие хүмүүс, шашны сургаалыг үндэслэгчид ба номлогчдын оюун санааны эрэл хайгуулын туршлагыг болон оюуны соёлын ололт амжилтын, түүний дотор философийн ололтын туршлагыг харуулдаг³.

Сэтгүүлчийн шинжлэх ухааны болон уран бүтээлийн танин мэдэх үйл ажиллагааны арга зүйн үндэс нь нийгмийг танин мэдэх шинжлэх ухааны ба уран сайхны гэсэн хоёр хэлбэрийг агуулдаг. Уран сайхны танин мэдэхүйн онцлог нь уран сайхны аргаар нээж өгсөн үзэгдлийн мөн чанар нь мэдрэхүйгээр хүлээж авсан хэлбэрээр буюу дүрээр илэрхийлэхэд оршдог. Уран дүрслэл, ил тод байдал сэтгүүл зүйг өдөр тутмын ердийн мэдлэгтэй ойртуулдаг, сэтгүүл зүйн үзэгдлийн мөн чанарыг нээх, ерөнхий, хамгийн гол, нийтлэг зүйлийг харуулах оролдлого нь шинжлэх ухааны танин мэдэхүйтэй ойртуулдаг. Уран сайхны танин мэдэхүй бол үнэлэмжийн шинжтэй байдаг нь философийн танин мэдэхүйтэй ойр байгаагийн шинж юм.

Энэ бүхнээс үзэхэд арга зүй гэдэг бол аргуудын агуулга ба хэлбэрийн тухай, тэднийг зөв хэрэглэх тухай мэдлэгийн систем юм. Түүний

гол зорилго нь аргуудын тусламж-тайгаар танин мэдэх үйл явцыг зөв оновчтой зохион байгуулахад оршино⁴.

Сэтгүүл зүй бодит байдлыг танин мэдэх олон төрлийн аргыг өөртөө агуулсан байдаг. Гэхдээ сэтгүүл зүйн арга зүйн төлөвших үйл явц нь бусад шинжлэх ухаантай нягт холбоотой явагдсаныг хэлэх хэрэгтэй. Энэ үйл явц өнөөдөр ч үргэлжилж байна. Сэтгүүл зүйн арга зүйн хүрээ үйл ажиллагааны

холимог салбараас шалтгаалан байнга баяжин гүнзгийрч байдаг онцлогтой. Гэхдээ сэтгүүл зүй бусад шинжлэх ухааны аргуудыг зүгээр нэг хуулбарлан хэрэглэх төдий биш, эсрэгээр тэднийг өөрийнхөө онцлог, хэрэгцээнд тохируулан баяжуулан хөгжүүлж байдгийг онцлох хэрэгтэй. Сэтгүүл зүй тийм салбар ухаануудын хоорондын хамтын ажиллагааны үндсэн дээр

өөрийнхөө танин мэдэхүйн арга зүйг боловсруулдаг. Эс тэгвэл сэтгүүл зүй хүмүүсийн “байнга өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн шаардлагыг хангахуйц нийгмийн хөгжлийн үр өгөөжийг дээшлүүлэх, нийгэм-улс төрийн харилцааг болон улс төрийн, оюуны, нийгмийн амьдралыг зохицуулахад шаардлагатай шуурхай, цаг үеэ олсон мэдээллийн”⁵ хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй гэдэг нь тодорхой.

Чухам энэ зорилгоор сэтгүүлч үзэгдэл, нөхцөл байдал, учирч буй

баримтуудыг янз бүрийн аргаар тайлбарлах, ухааран ойлгох, тунгаан бодохыг хичээдэг. Бодит байдлыг таньж мэдэх, өөрийн болгох явцад “сэтгүүлч шинжлэх ухааны, шинжлэх ухааны бус, туршилтын зэрэг олон янзын мэдлэгтэй тулгардаг. Тиймээс түүний үнэн бодитой эсэхийг шалгах асуудал зайлшгүй гарч ирдэг. Ихэнх тохиолдолд сэтгүүлчийн бичсэн зүйл нь үнэн бодитой эсэх нь бодит байдлыг

таньж мэдэх аргуудыг эзэмшсэн түвшнээс шууд шалтгаалдаг. Сэтгүүлчийн туйлын зорилго нь үнэнийг олох, түүнийг хүлээн авагчдад зөв, оновчтой хүргэхэд оршино”⁶.

Сэтгүүл зүйн өөр нэг онцлог шинж нь түүний тусгаж буй объектууд нь маш олон янз, бараг ямар ч хэмжээ хязгааргүй байдагтай холбоотой юм. Түүний нөлөөллийн объект нь метамэдээллийн

нэгж хүртлэх нийгмийн байгууллагын бүх үйл явц, түвшин байдаг. Сэтгүүл зүйн объектийн хүрээ бол хүмүүсийн, хэсэг бүлгийн эсвэл хувь хүний ухамсар, зан байдал, тэдний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийн тухай ойлголт болдог онцлогтой.

Сэтгүүлч туршилтын, онолын гэсэн хоёр түвшинд ажилладаг. Баримт мэдээллийг цуглуулах явцад сэтгүүлч шууд судалгааны объекттай ажиллах бөгөөд энэ нь гол төлөв туршилт, ажиглалтаас эхэлдэг. Мэдээллийг цуг-



Сэтгүүл зүйн арга зүйн хүрээ үйл ажиллагааны холимог салбараас шалтгаалан байнга баяжин гүнзгийрч байдаг онцлогтой. Гэхдээ сэтгүүл зүй бусад шинжлэх ухааны аргуудыг зүгээр нэг хуулбарлан хэрэглэх төдий биш, эсрэгээр тэднийг өөрийнхөө онцлог, хэрэгцээнд тохируулан баяжуулан хөгжүүлж байдгийг онцлох хэрэгтэй. Сэтгүүл зүй тийм салбар ухаануудын хоорондын хамтын ажиллагааны үндсэн дээр өөрийнхөө танин мэдэхүйн арга зүйг боловсруулдаг



луулж туршилтын баазаа бүрдүүлж дуусах нь дүн шинжилгээний дараагийн түвшин буюу баримт мэдээллийг системчлэх үйл явц руу шилжих боломж олгодог. Тиймээс сэтгүүл зүйн онолын хувьд арга зүйн асуудлыг боловсруулах нь онцгой чухал байдаг.

Арга бол бүх үйл ажиллагааг шаардлагтай чиглэлд заалж өгдөг өвөрмөц луужингийн үүргийг гүйцэтгэдэг. Арга гэдэг ойлголт өөрөө грек хэлний “танин мэдэх үйлдэл, ямар нэгэн зүйл руу орох зам” гэсэн утга санааг илэрхийлдэг нь ч үүнтэй холбоотой юм. Аргын үндсэн үүрэг нь танин мэдэх эсвэл аливаа объектийг практикийн хувьд өөрчлөх үйл явцыг зохион байгуулах, зохицуулахад оршино. Үүнтэй холбоотой судлаач В.П.Кохановский: “Арга бол танин мэдэхүйн үйл ажиллагааны тодорхой дэг журам, үйлдэл, хэм хэмжээний нийлбэрээр хязгаарлагддаг. Мөн үйл ажиллагааны аль нэг салбарт тодорхой зорилтыг шийдвэрлэх, тодорхой үр дүнд хүрэхэд судлаачийг удирдан чиглүүлж өгдөг зарчим, шаардлага, удирдамжийн систем юм. Арга үнэнийг олох эрэл хайгуулыг дэг журамтай, оновчтой болгох, хүч хөдөлмөр, цаг хугацаа хэмнэх, хамгийн богино замаар зорилгодоо хүрэхэд тусалдаг”⁷ гэсэн маш оновчтой дүгнэлт хийсэн байдаг.

Энэ бүхнээс үзэхэд өнөөдөр арга гэдгийг дараах утгаар ойлгодог байна.

Үүнд:

1. Байгалийн болон нийгмийн амьдралын үзэгдлүүдийг судлах, таньж мэдэх үйлдэл (диалектик арга, туршилтын арга, харьцуулан судлах арга).
2. Аливаа үйл ажиллагаанд хэрэглэх үйлдэл, үйлдлийн систем юм.

Ер нь үйл ажиллагааны аль ч салбарт хүмүүс өөрийн гэсэн тусгай аргуудыг боловсруулсан байдаг. Шинжлэх ухааны болон уран сайхны аргууд ч ийм замаар үүсч, төлөвшсөн түүхтэй.

Үндэс суурийг нь объектив байдал, шинэ зүйлд нээлттэй байх, баяжин хөгжиж байдаг онцлог бүрдүүлдэг шинжлэх ухааны аргыг хүн төрөлхтний оюун санааны агуу их нээлт гэж хэлж болно. Энэ аргыг цаг хугацаа болон оюуны нөөц боломжийг хамгийн багаар хэмнэх шаардлагын үүднээс сонгож авсан бөгөөд энэ түвшинд хөгжиж ирсэн түүхтэй. Аливаа хөгжилд зайлшгүй тулгардаг элемент бол төөрөгдөл байдаг. Тэгвэл шинжлэх ухааны арга бол хөгжлийг тогтвортой байлгах, төөрөгдлөөс урьдчилан сэргийлэх боломжоор хангадаг давуу талтай.

Хэрэв шинжлэх ухааны танин мэдэхүйн аргууд XVII зууны эхэнд үүссэн бол сэтгүүл зүйн аргуудын төлөвших түүх нь харьцангуй богино. Зөвхөн XX зууны 70-80-аад оны үед судлаачид сэтгүүл зүйн аргуудын системийг боловсруулах талаар идэвхтэй ярьж эхэлжээ. Энэ асуудлыг дэвшүүлэн тавих шаардлага бол сэтгүүл зүйн онолд нийтлэл зүйн үндсэн аргыг тодорхойлох нэгдсэн хандлага байгаагүйтэй холбоотой юм. Тухайлбал, Оросын сэтгүүл зүй судлаач В.М.Горохов тухайн үед “Нийтлэл зүйн аргыг тодорхойлоход учирч буй хүндрэл бол энэ нэр томъёог одоо хүртэл нэг мөр ойлгож, хүлээж авч чадаагүй байгаатай холбоотой. Судлаачдын нэг хэсэг нь түүнийг материалист диалектикийн танин мэдэхүйн ерөнхий аргад, хоёр дахь хэсэг нь хүлээн авагчдад нөлөөлөх аргад, гурав дахь хэсэг нь цэвэр утга зохиол-нийтлэлийн аргад оруулдаг. Хамгийн

гол нь нийлэлчийн бүтээлч үйл ажиллагааны энэхүү янз бүрийн аргуудыг зөвхөн нэгтгэх төдий бус, үйл ажиллагааны нэгдмэл чанарыг хангахуйц түүний өөр өвөрмөц шинжийн тухай ярих нь зөв юм. Энэ нь нийтлэлчийн ерөнхий аргыг бүрдүүлэг ёстой юм”⁸ гэж тэмдэглэсэн байдаг. Ийм маягаар сэтгүүл зүйн үндсэн аргыг нийтлэл зүйн бүтээлээр дамжуулан тодорхойлох гэсэн оролдлого нь нэгдүгээрт, шинжлэх ухааны танин мэдэхүйн, уран сайхны болон цэвэр нийтлэл зүйн аргын хоорондох ялгааг тодруулах, хоёрдугаарт, аргын ертөнцийг үзэх үзлийн категори болох онцлогийг тодорхойлох, гуравдугаарт, аргын үйл ажиллагааны субъектив категори болохыг нотлох боломж олгосон юм. Тэрээр сэтгүүл зүйн танин мэдэхүйн аргын онцлогийг тодорхойлохдоо “сэтгүүл зүйд танин мэдэхүйн аргыг хэрэглэх нь хийсвэр үнэнд хүрэхээс арай өөр зүйл юм. Сэтгүүл зүй дэх үнэн гэдэг бол бүтээлч үйл ажиллагааны үл төгсөх үйл явц юм. Харин хүлээн авчдад үр ашигтай нөлөөлөхөд шаардлагатай хамгийн гол нөхцөл бол сэтгүүл зүй ба олон нийтийн ухамсрын, мөн тэдний нийгмийн практикийн хоорондох маш чухал, зарчимч үе шат мөн”⁹ гэж тэмдэглэсэн нь оновчтой, зөв дүгнэлт юм. Үнэн хэрэг дээрээ сэтгүүл зүйд бүтээлч ажиллагааны эцсийн шат нь үнэнийг эрж хайх бус, харин олон нийтийн мэдээллийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн бие даасан тусгай бүтээл бэлтгэх замаар мэдээллийн нөлөө үзүүлэх явдал юм. Үнэнийг олох асуудал бол бүтээлч үйл ажиллагаагаасаа илүү хүний танин мэдэхүйн үйл ажиллагаатай холбоотой асуудал юм. Тийм учраас танин мэдэхүйн аргуудыг сэтгүүл зүйд хэрэглэх тухай ярихдаа

юуны өмнө шинжлэх ухааны танин мэдэхүйн аргуудыг сэтгүүл зүйн онцлогт нийцүүлэн хувиргах, мөн синтез (нэгтгэн дүгнэх), хийсвэрлэх, ерөнхийлөн дүгнэх зэрэг цэвэр шинжлэх ухааны аргуудыг сэтгүүлчийн бүтээлч ажилд ашиглах боломжийг эрж хайх нь чухал юм. Энэ тохиолдолд сэтгүүл зүйн арга гэж чухам юуг нэрлэх вэ гэсэн асуудал нээлттэй үлдэх нь тодорхой. Зөвхөн “олон нийтэд үр ашигтай нөлөөлөх” аргаар хязгаарлагдах нь учир дутагдалтай гэдэг нь ойлгомжтой.

Зарим судлаач бодит байдлыг сэтгүүл зүйн үүднээс тусгах буюу баримтыг судлахыг шинжлэх ухаантай хослох нь нийтлэл зүйн аргын гол онцлог гэж үздэг¹⁰ нь оргүй зүйл биш юм. Энэ бол өргөн утгаар нь баримтат шинжийг нийтлэлчийн ертөнцийг үзэх онол-үзэл санаатай хосолж хэрэглэнэ гэсэн үг юм. Гэхдээ энэ нь нийтлэлчийн бүтээлч ажиллагааны зөвхөн нэг л чухал элемент буюу бодит байдлыг баримтад үндэслэн тусгах аргын тухай ярьж буй хэрэг юм. Харин нийгмийг сэтгүүл зүйн үүднээс танин мэдэх аргатай холбоотой бүх зүйл анхаарлын гадуур үлдсэн гэсэн үг.

Бодит байдлыг тусгах баримтат шинж гэдэг бол шинжлэх ухаанд ч, уран сайхны бүтээлийн зарим төрөлд ч байдаг зүйл. “Тиймээс баримтат чанар гэдэг бол утга зохиолын бүтээлийн зарим төрлийн, түүний дотор сэтгүүл зүйн гол шинжүүдийн нэг болох юм”¹¹. Чухам үүнээс шалтгаалан энэ нь сэтгүүл зүйн универсаль арга болж чадахгүй. Харин сэтгүүл зүйн танин мэдэхүйн судлагдахууны онцлогийг харгалзан боловсруулсан аргын тухай профессор Е.П.Прохоровын санаа нэлээд сонирхолтой, үр дүнтэй санагддаг. Түүний бодлоор “...судлагдахууныг

таньж мэдэх нь түүнд тохирсон аргын тусламжтайгаар явагдах бөгөөд түүнийг үүрэг ба судлагдахуунтай салшгүй холбоонд нь авч үзэх хэрэгтэй. Судлагдахууныг таньж мэдэх явцад аргыг хэрэглэсний үр дүн нь агуулга ба хэлбэрийн нэгдлийг хангасан бие даасан бүтээл турвих явдал юм. Тийм хандлагын явцад хэлбэрийн ерөнхий онцлогууд нь зүй тогтлын шинжүүдийг агуулдаг, зүй тогтлын онцлог нь юуны өмнө арга, судлагдахуун болон зорилгоор урьдчилж тодорхойлогдсон агуулгын онцлогоос урган гардаг¹² байна. Энд судлаач сэтгүүл зүйн үйл ажиллагааны аргын тухай асуудлыг шийдвэрлэхэд онцгой чухал үүрэгтэй “танин мэдэхүйн ямар ч төрлийн аргыг түүний судлагдахуун нь шууд урьдчилж тодорхойлдог”¹³ гэсэн санал дэвшүүлжээ.

Сэтгүүл зүйн танин мэдэхүйн аргын судлагдахуун нь нийгмийн ямар ч объект байж болно. Энд сэтгүүлчийн үйл ажиллагаанд арга бол үйл ажиллагааны эхлэх цэг ба бие даасан бүтээл туурвих дараа дараагийн бүх ажлын урьдач нөхцөл болдог онцлогтой. “Ерөнхий утгаар нь аргыг мэдлэгийн (ерөнхий болон сэтгүүл зүйн тусгай) нийлбэр гэж тодорхойлж болох бөгөөд түүнийг бүтээлч үйл ажиллагааны аргын хувьд ашигласнаар агуулга ба хэлбэрийн нэгдлийг хангасан бүтээл туурвихад хүргэдэг”¹⁴ байна.

Дээрх асуудлыг шийдэхийн тулд сэтгүүлч юу мэдэх ёстой вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдах учиртай. Харин түүний хариулт нь сэтгүүлчийн танин мэдэхүйн бүтээлч үйл ажиллагааны арга зүйн үндсийг бүрдүүлэх боломжтой. Энэ бүхнээс үзэхэд сэтгүүлчийн бүтээлч ажлын аргыг тодорхойлохтой холбоотой асуудлыг

зөвхөн бодит байдлыг таньж мэдэх сэтгүүлчийн одоо байгаа аргууд ба хэлбэрүүдийг хүн төрөлхтний үйл ажиллагааны бусад хэлбэрүүдтэй нэгтгэн дүгнэх арга зүйн түвшинд шийдвэрлэх боломжтой.

Энэ чиглэлийн талаарх ойлголт болон түүний ирээдүй онолчдыг сэтгүүл зүйн танин мэдэхүйн аргын танин мэдэхүйн бусад хэлбэрийн системд эзлэх байрын талаар өөрсдийн санал бодлыг дэвшүүлж, улам гүнзгийрүүлэн авч хэлэлцэхэд хүргэсэн юм. Нэрт онолч В.М.Горохов сэтгүүлчийн бүтээл дэх танин мэдэхүйн аргуудын нийтлэг шинжийг тодорхойлдог дараах 5 түвшнийг санал болгосон байдаг. Үүнд:

- Философийн түвшин (материалист диалектикийн болон түүхэн материалист арга зүй);
- Сэтгүүл зүйн нийгмийн үүргүүдтэй нийцүүлэн түүний үйл ажиллагаанд хэрэглэдэг шинжлэх ухааны танин мэдэрүйн ерөнхий аргууд;
- Сэтгүүл зүйд хэрэглэх шинжлэх ухааны тусгай аргууд (санал асуулга, сэтгэл зүйн ажиглалт, эдийн засгийн дүн шинжилгээ г.м.);
- Салбар ухаануудын хоорондын аргууд (бодит байдлыг тусгах уран сайхны болон шинжлэх ухааны аргуудыг хослон хэрэглэх);
- Тухайн нөхцөл байдлын тодорхой онцлог, бичиж буй бүтээлийн гол утга санаа болон хүлээн авагчдын өвөрмөц онцлогт тохирсон бүтээлч ажлын арга, үйлдлүүд¹⁵ юм.

Энд бодит байдлыг таньж мэдэх философийн түвшнийг онцлон тодорхойлсон нь үндэслэлтэй гэдэг нь ойлгомжтой. Учир нь ертөнцийг таньж мэдэх шинжлэх ухааны аргыг боловсруулахад хамгийн түрүүнд үнэтэй хувь нэмэр оруулсан судлаачид бол

философичид юм. Үүнтэй холбоотой орчин үеийн онолчид Сократ ба Платоны диалектик аргыг, Ф.Беконь индуктив аргыг, Р.Декартын рациональ аргыг, И.Фихтегийн антитетик (эсрэг тэсрэгийн) аргыг, Г.Гегель ба К.Марксын диалектик аргыг, Э.Гуссерлийн феноменологийн аргыг онцлон тэмдэглэдэг. Тиймээс арга зүй өнөөдөр хүртэл философитой, ялангуяа түүний гносеологи (танин мэдэхүйн онол), диалектик зэрэг салбаруудтай салшгүй холбоотой юм.

Сэтгүүл зүйд философийн шинжлэх ухааны хандлагуудыг ч хэрэглэх боломжийн талаарх судлаач А.С.Колесниковын санал анхаарал татдаг. Гэхдээ философийн аргууд зөвхөн судалгааны ерөнхий чиглэлийг зааж, ерөнхий үр дүнгийн талаар чиг баримжаа олгож, ерөнхий стратегийг боловсруулахад чухал үүрэгтэй гэдгийг мартаж болохгүй.

Харин шинжлэх ухааны ерөнхий аргууд буюу танин мэдэхүйн логик аргууд, үйлдлүүд бол шинжлэх ухааны бүх салбарт, түүний дотор сэтгүүл зүйд өргөн хэрэглэгддэг. Түүнд уламжлалт ёсоор задлан шинжлэх (анализ) ба нэгтгэн дүгнэх (синтез), хийсвэрлэх, ерөнхийлөн дүгнэх, индукци ба дедукци, идеализаци (хэт сайнаар төсөөлөх), аналогийн аргууд багтдаг. Тэднийг шинжлэх ухааны аль ч салбарын

болон сэтгүүл зүйн үйл ажиллагаанд чөлөөтэй, универсаль шинжтэй ашигладаг.

Өнгөрсөн жилүүдэд шинжлэх ухааны танин мэдэхүйн ерөнхий аргууд болон логикийн аргуудыг сэтгүүл зүйг нийгэмчлэх үйл ажиллагаа өндөр түвшинд явагдсантай холбоотой сэтгүүл зүйд нэлээд идэвхтэй хэрэглэж ирсэн бол сүүлийн арван жилд дээр дурдсан философийн түвшний өөрчлөлтийн улмаас бас томоохон байр

эзлэх болжээ. Шинжлэх ухааны бүтээлүүдэд тийм аргуудад ажиглалт, туршилт, анализ, синтез, индукци, дедукци, ерөнхийлөн дүгнэх, аналог, харьцуулалт зэрэг аргуудыг оруулсан байдаг¹⁶.

Сэтгүүл зүйд шинжлэх ухааны тусгай аргуудыг хэрэглэх хэрэгцээ, шаардлага юуны өмнө сэтгүүл зүйн уламжлалт аргуудыг (ярилцлага, ажиглалт, баримт бичигтэй ажиллах

г.м.) орчин үеийн нийгэмд эрчимтэй явагдаж байгаа ээдрээтэй, зөрчилтэй нийгмийн болон сэтгэл зүйн үзэгдлүүдийг тайлбарлахад хангалтгүй болсонтой холбоотой юм. Тиймээс сэтгүүл зүйн уламжлалт аргуудын хүрээг өргөтгөж, байнга баяжуулах шаардлага тулгарсан. Чухам үүнтэй холбоотой объектийг судлах янз бүрийн арга, хандлагуудыг хосолсон судалгааны салбар ухаануудын аргууд бий болсон юм.



Сэтгүүл зүйд шинжлэх ухааны тусгай аргуудыг хэрэглэх хэрэгцээ, шаардлага юуны өмнө сэтгүүл зүйн уламжлалт аргуудыг (ярилцлага, ажиглалт, баримт бичигтэй ажиллах г.м.) орчин үеийн нийгэмд эрчимтэй явагдаж байгаа ээдрээтэй, зөрчилтэй нийгмийн болон сэтгэл зүйн үзэгдлүүдийг тайлбарлахад хангалтгүй болсонтой холбоотой юм. Тиймээс сэтгүүл зүйн уламжлалт аргуудын хүрээг өргөтгөж, байнга баяжуулах шаардлага тулгарсан



Сүүлийн жилүүдэд мэдээллийн шинэ технологийн үсрэнгүй хөгжил, хэрэглэгчдийн нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээ, өөрчөлтийг шуурхай мэдэх шаардлагын улмаас сэтгүүл зүйд нийгэм-сэтгэл зүйн, социологийн, нийгэм-эдийн засгийн аргуудыг өргөн хэрэглэж эхэлсэн. Энд янз бүрийн төрлийн социологийн санал асуулгууд, контент-анализ (агуулгын дүн шинжилгээ), медиагийн зах зээлийг судлах маркетингийн аргууд, консалтингийн (зөвлөх) үйлчилгээ зэрэг цөөнгүй аргыг нэрлэж болно.

Сэтгүүл зүйн бүтээлийг бэлтгэхтэй холбоотой аргууд гол төлөв сэтгүүлчдийн бие даасан, хувийн үйл ажиллагааны түвшинд боловсорч бий болдог. Энэхүү туршлагыг судлах, нэгтгэн дүгнэх нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны онол, практикийн хувьд үнэ цэнэтэй, ач холбогдолтой юм. Тиймээс Оросын судлаачийн санал болгосон ангиллын үнэ цэнэ, ач холбогдол нь түүнд зөвхөн шинжлэх ухааны ерөнхий ба тусгай аргуудыг сэтгүүл зүйн аргуудтай харьцуулах төдийгүй, сэтгүүл зүйн аргын хамгийн гол шинжүүдийг нэлээд өндөр түвшинд ялгаж, тодорхойлж өгсөнд оршино.

Сэтгүүл зүйн универсаль аргыг тодорхойлохыг оролдсон өөр нэг судлаач бол “Сэтгүүл зүйн арга ба сэтгүүлчийн үйл ажиллагааны аргууд” (1998) хэмээх сонирхолтой нэг сэдэвт бүтээлийг зохиогч Узбекистаны эрдэмтэн Ф.А.Муминов юм. Тэрээр гурван субстанцид (ертөнцийн ерөнхий байдал, нөхцөл байдал ба үйл хөдлөл) орших бодит байдлын тухай Гегелийн сургаалыг үндэслэн диалектик бол нийгмийн болон байгалийн хамгийн ерөнхий, универсаль хуулиудыг илрүүлдэг бол салбар шинжлэх ухаанууд нөхцөл байдал ба үйл хөдлөлийг судалдаг. Үүний үндсэн дээр сэтгүүл зүйн универсаль арга бол диалектик ба салбар ухаануудын хооронд оршиж, юуны өмнө нийгмийн санаа бодлыг шуурхай тодорхойлдог гэсэн дүгнэлт хийжээ. Гэхдээ энэ бол зөвхөн таамаглал төдий зүйл бөгөөд үнэн эсэхийг ирээдүйн судалгааны үр дүн харуулах биз ээ.

Бидний бодлоор сэтгүүл зүйн ерөнхий аргыг тодорхойлохын бэрхшээл нь түүний үйл ажиллагаа нь янз бүрийн түвшинд, янз бүрийн чиглэлд, өөрөөр хэлбэл практикийн, оюуны, хамт олны, хувь хүний болон бодит байдлыг танин мэдэх, ухааран ойлгох шинжлэх ухааны, уран сайхны ба ердийн ухамсрын түвшинд оршдогтой холбоотой юм. Энэ бүхнээс үзэхэд сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээ нь маш өргөн учраас сэтгүүл зүйн ертөнцийг таньж мэдэх онцлогийг тодорхойлж чадахуйц ямар нэгэн универсаль аргыг илрүүлэх нь амаргүй бөгөөд орчин үеийн сэтгүүл зүйн судлалын тулгамдсан асуудлуудын нэг мөн. Гэхдээ энэхүү универсаль аргыг зөвхөн арга зүйн түвшинд боловсруулах боломжтой гэдэг нь тодорхой юм.

Ишлэл

- ¹Мельник Г.С., Ким М.Н. Методы журналистики. СПб., 2008. с.10-11.
- ²Смагин Ю.Е. Оккультная философия и становление английского эмпиризма //”Философские науки”. 2004. №11. С.35, 85.
- ³Мельник Г.С., Ким М.Н. Указ. соч. с.20-25.
- ⁴Муминов Ф.А. Метод журналистики и методы деятельности журналистов: Монография. Ташкент. 1998. с.41.
- ⁵Мельник Г.С., Ким М.Н. Указ. соч. с.5.
- ⁶Там же. с.5-8.
- ⁷Кохановский В.П. Философия и методология науки: Учебник для вузов. Ростов-на-Дону. 1999. с.168.

- ⁸Горохов В.М. Закономерности журналистского творчества. М., 1975. с.72.
- ⁹ Там же. с. 115.
- ¹⁰Учёнова В.В. Публицистика и политика. М., 1979. с. 220.
- ¹¹Здровега В.И. Слово тоже есть дело. Некоторые проблемы теории публицистики. М., 1979. с. 44.
- ¹²Прохоров Е.П. Публицистика и действительность. М., 1973. с.11.
- ¹³ Там же. с.313-314.
- ¹⁴Прохоров Е.П. Методология журналистского творчества и проблема классового анализа // Мастерство журналиста /Под ред. В.М.Горохова и В.Д.Пельта/. М., 1977. с.47.
- ¹⁵Горохов В.М. Основы журналистского мастерства. М., 1989. с.42.
- ¹⁶Философская копаративистика в диалоге культур // Философские науки. 2004. №11, с.94.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Горохов В.М. Закономерности журналистского творчества. М., 1975.
2. Горохов В.М. Основы журналистского мастерства. М., 1989.
3. Здровега В.И. Слово тоже есть дело. Некоторые проблемы теории публицистики. М., 1979.
4. Кохановский В.П. Философия и методология науки: Учебник для вузов. Ростов-на-Дону. 1999.
5. Мельник Г.С., Ким М.Н. Методы журналистики. СПб., 2008.
6. Муминов Ф.А. Метод журналистики и методы деятельности журналистов: Монография. Ташкент. 1998.

7. Прохоров Е.П. Публицистика и действительность. М., 1973.
8. Прохоров Е.П. Методология журналистского творчества и проблема классового анализа // Мастерство журналиста /Под ред. В.М.Горохова и В.Д.Пельта/. М., 1977.
9. Смагин Ю.Е. Оккультная философия и становление английского эмпиризма //”Философские науки”. 2004. №11.
10. Учёнова В.В. Публицистика и политика. М., 1979.
11. Философская копаративистика в диалоге культур // Философские науки. 2004. №11.

Резюме

Статья посвящена одному из важнейших проблем теории и практики журналистики об определении универсального метода журналистики. Автор опираясь на многочисленные выводы, гипотезы, предположения и конструктивные мнения учёных и исследователей журналистики разных стран делает вывод о том, что выработка такого универсального метода возможна только на методологическом уровне. По-мнению автора трудности в определении общего метода журналистики связаны с тем, что журналистская деятельность разворачивается на разноплановых уровнях начиная с практического до уровня обыденного познания действительности.